



БҮХ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДЫН
АНХААРАЛД

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

45063 Дархан-Уул аймаг, Дархан сум, 5 дугаар баг

Утас/Факс: 976-7037-4303

И-мэйл хаяг: darkhan.emg@gmail.com

Вэб сайт: <http://www.darkhan-uul.mohs.mn>

2022.02.17 № 92

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Агниста фарм ХХК нь Багц №26 “Эмнэлгийн хэрэгсэл-5 /Нэг удаагийн зүү тариур/ Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн” тендерт дотоодод үйлдвэрлэгддэг нэг удаагийн тариуруудыг импортын бүтээгдэхүүнүүдтэй хамт багцлаж зарласан байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10¹. “Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглоно” дэх заалтын дагуу тусад нь багцлаж зарлана уу. гэж тодруулга авах тухай хүсэлт ирүүлсэн байна.

Манай байгууллага ДАЭМГ/202301048 дугаартай “Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах (Аймгийн хэмжээнд)” тендерийн барааг багцлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6. “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно.” гэж заасны дагуу багцлаж зарласан. Энэ нь “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ыг шинэчлэн батласан Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор баталсан 7. “Эм, био бэлдмэл” бүлгийн 7.2. Эмнэлгийн хэрэгсэл, халдвар хамгааллын хувцас хэрэглэл (нэг удаагийн тариур, зүү, дуслын систем, цусны уут, шээсний уут, малгай, амны хаалт, халат, улавч, ороох боох материал гэх мэт) гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж байна.

Учир нь олон улсын жишигт зүү, тариур үйлдвэрлэгч нь нэг удаагийн зүү, тариурыг эмчилгээний зориулалтын дагуу хамтад нь болон зүүг тусад нь савлагаатайгаар үйлдвэрлэдэг. Иймд Монгол Улсад Нэг удаагийн тариур үйлдвэрлэдэг ба зүү тариурыг хамтад нь болон зүүг тусад нь савлах нь тухайн үйлдвэрлэгчийн асуудал бөгөөд үйлдвэрлэгч бүрийн савлалтанд тохируулж тендер зарлах боломжгүй болохыг мэдэгдэж байна.

Цаашид үндэсний үйлдвэрлэгч нар өөрийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний талаарх мэдээ, мэдээллээр эрүүл мэндийн байгууллагуудыг хангаж хамтран ажиллахыг хүсье.

ДАРГА


Б.БАТЦЭНГЭЛ
